

ЗОРИЛТОД САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА

I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Энэхүү гарын авлага нь Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 6.1.4 дэх заалтыг мөрдөхөд чиглэсэн болно.
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (цаашид МУТСТХууль гэх)-ийн 4.1 дэх заалтад заасан мэдээлэх үүрэгтэй этгээд (цаашид МҮЭ гэх)-ийг терроризмыг санхүүжүүлэх (цаашид ТС гэх), үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (цаашид ҮОХЗДС гэх)-ийн эсрэг энэхүү хууль болон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д заасан зорилтот санхүүгийн хориг арга хэмжээ (цаашид хориг арга хэмжээ гэх)-г авах үүргийг хэрэгжүүлэх, “Террорист этгээдийг жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам”-ыг хэрэгжүүлэхэд зориулагдсан болно.
3. Дээрх хууль, тоогтоомж, журмууд нь Мөнгө угаахтай тэмцэх, санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (цаашид ФАТФ гэх)-аас гаргасан Зөвлөмж 6 (терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хориг арга хэмжээ), Зөвлөмж 7 (үйл олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийн эсрэг хориг арга хэмжээ)-д заасан зүйлийг тусгасан болно.

Хууль, эрх зүйн үндэслэл

4. *Олон улсын хууль тогтоомж*

Монгол улс НҮБ-ийн Дүрмийн Бүлэг VII-д заасны дагуу НҮБ-ын Аюулгүйн зөвлөл (цаашид НҮБАЗ гэх)-ийн гаргасан шийдвэрүүдийг гишүүн орнууд шууд хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг байна. НҮБ-ээс Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг олон улсын конвенцийг 1999 онд боловсруулж, Монгол улс түүнийг баталсан болно.

НҮБ-ийн Аюулгүй байдлын зөвлөл (цаашид НҮБАЗ гэх)-өөс дараах тогтоол гарсан. Үүнд:

- ❖ НҮБАЗ-ийн 1999 онд баталсан 1267 дугаар тогтоолоор Ал-кайда болон Талибан бүлэгтэй холбоотой этгээдийн эсрэг хориг арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн;
- ❖ НҮБАЗ-ийн 2001 онд баталсан 1373 дугаар тогтоолоор улс орнууд терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хориг арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн;
- ❖ НҮБАЗ-ийн 2006 онд баталсан 1718 дугаар тогтоолоор БНАСАУ улсын эсрэг хориг арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн;
- ❖ НҮБАЗ-ийн 1737 дугаар тогтоолоор Иран улсын эсрэг хориг арга хэмжээ авахаар тус тус шийдвэрлэсэн болно.

Дээрх НҮБАЗ-ийн тогтоолуудыг Тагнуулын байгууллага (Тагнуулын ерөнхий газар)-ын цахим хуудаснаас лавлаж болно. Бүлэг VIII-д НҮБАЗ-ийн тогтоолуудын дэлгэрэнгүй жагсаалтыг хавсаргав.

Монгол улсын хууль тогтоомж.

Монгол Улсын Их Хурал Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг 2013 онд баталсан.

- ❖ Тус хуулийн 6¹.1 дэх заалтад “НҮБАЗ-өөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад нийцүүлэн Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6.1.4-т заасны дагуу баталсан хориг арга хэмжээний жагсаалт (цаашид жагсаалт гэх)-д орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно” гэж заасан.

Монгол Улсын Их Хурал “Терроризмтэй тэмцэх тухай хууль”-ийг 2004 онд баталсан.

- ❖ Энэхүү хуулийн 2.1 дэх заалтад “терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бүхий л зохицуулалтад үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх аливаа үйл ажиллагаа нэгэн адил хамаарна” гэж зааснаар ТС болон ҮОХЗДС-ийн эсрэг үйл ажиллагааг эрх зүйн хувьд адил зохицуулалттай болгосон;
- ❖ Хуулийн 6.1.4 дэх заалтад терроризмоос сэргийлэхэд Засгийн газар террорист этгээдийн жагсаалт батлах, жагсаалтаас гаргах, түүнийг хянах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, жагсаалтад алдаатай нэрс оруулснаас үүсэх хохирлыг шийдвэрлэх, гэм буруугүй этгээдийн хөрөнгийг гэм буруутай этгээдийн хөрөнгөөс тусгаарлахтай холбоотой журмыг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн батлах эрхтэй гэж заасан.
- ❖ Хуулийн 9.1.6 дэх заалтад террорист үйлдлийн эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “террор ажиллагаа, террорист үйлдэлд ашиглаж байгаа буюу ашиглахад зориулсан эд хөрөнгө, мөнгө, террорист ажиллагаа, террорист үйлдлээс олсон орлогыг илрүүлэх, хураах” үйл ажиллагаа хамаарахаар заасан.

Дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор дараах журмууд батлагдсан. Үүнд:

- ❖ Засгийн газрын 2019 оны 54 дүгээр тогтоолоор “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, хянах журам” (цаашид Терроризмын эсрэг журам гэх);
 - ❖ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”.(цаашид Терроризмоос урьдчилан сэргийлэх журам гэх)
5. Дээрх хууль, журмыг харилцагчийн үнэлсэн эрсдэлээс үл хамааран заавал биелүүлэх үүрэг хүлээнэ.

ТС, ҮОХЗС-ийн эсрэг хориг арга хэмжээ нь тухайн харилцагчийн эрсдэлийн үнэлгээ болон үйл ажиллагаа, үйлчилгээний эрсдэлийн үнэлгээнээс үл харгалзан МУТСТХууль, Терроризмтэй тэмцэх тухай хууль болон Терроризмын эсрэг журамд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй болно. (Террорист этгээдийн жагсаалтыг цаашид жагсаалт гэнэ)

Дээр дурьдсаныг нэгтгэж дүгнэхэд, ТС, ҮОХЗС-ийн эсрэг хориг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах хууль тогтоомжийг удирдлага болгоно:

- ❖ Монгол Улсын Үндсэн хууль;

- ❖ Терроризмтой тэмцэх тухай хууль;
- ❖ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- ❖ Эрүүгийн хууль;
- ❖ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль;
- ❖ Зөрчлийн тухай хууль;
- ❖ Тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад акт.

Хориг арга хэмжээ хэрэгжүүлэх

6. Зорилгод санхүүгийн хориг арга хэмжээ

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хуульд заасан эрх бүхий байгууллага болон Санхүүгийн мэдээллийн алба (цаашид СМА гэх)-аас өөрөөр шийдвэрлээгүй бол НҮБАЗ-ийн тогтоол болон холбогдох хууль тоогтоомжид заагдсан хүн болон хуулийн этгээд (цаашид этгээд гэх)-ийн шууд болон шууд бусаар эзэмшиж буй, эсвэл хянаж буй санхүүгийн хөрөнгийг шууд болон шууд бусаар ашиглах, зарцуулах боломжгүй болгох, эдийн засгийн эх үүсвэр, данс, актив хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, гүйлгээ хийх эрхгүй болгох зэрэг (цаашид царцаах гэх) хориг арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

7. Царцаах хориг арга хэмжээ авагдах хөрөнгийн тодорхойлолтыг дээрх хууль тогтоомж, журам заавар, ФАТФ-ын Зөвлөмж 6, 7-д заасны дагуу ойлгоно. Тус гарын авлагын Бүлэг VIII-д зарим нэр томъёоны тайлбарыг хавсаргав.

8. Жагсаалтад орсон этгээдэд нэн даруй хориг арга хэмжээг хэрэгжүүлэх

- ❖ Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 7.1.7 дахь заалтад зааснаар дараах албан ёсны баримт бичгийг үндэслэн хориг арга хэмжээ авна:
 - НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан тогтоолын дагуу;
 - Гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг харгалзаж үзсэний дагуу;
 - Тагнуулын байгууллагаас гаргасан жагсаалтад орсон.
- ❖ Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 8.2 дахь заалтын дагуу Монгол Улс дахь санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч хүн, хуулийн этгээд (цаашид санхүү, бизнесийн этгээд гэх) нь жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд, эсхүл түүнийг төлөөлж буй этгээдийн талаар дараах арга хэмжээ авна:
 - Тагнуулын байгууллага болон СМА-нд 48 цагийн дотор мэдэгдэнэ;
 - Шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогыг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр нэн даруй зогсооно;

- Шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

9. “Хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, гүйлгээ хийх эрхгүй болгох” буюу царцаах гэдэг нь Терроризмын эсрэг журмын 5.3 дахь заалтад зааснаар доор дурьдсан дараах хөрөнгийг адилтган үзэж, хөдөлгөөнийг хориглоно:

- ❖ Зөвхөн тодорхой террорист үйлдэл, хуйвалдаан, заналхийлэлд хамаарах бус, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
- ❖ Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд буюу шууд бусаар эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүхий л мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
- ❖ Дээрх хөрөнгөөс бий болсон мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө, мөн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн заавраар, тэдгээрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж буй хүн, хуулийн этгээдийн мөнгөн хуримтлал буюу бусад хөрөнгө;
- ❖ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолоор жагсаалтад оруулсан усан тээврийн хэрэгсэл;
- ❖ Хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоосон хүн, хуулийн этгээдийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой төлбөр, хүүгийн болон бусад төлбөрийг мөн адил зогсооно.

10. Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй этгээд

Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа этгээд, эсвэл Монгол Улсын харьяалалтай этгээд манай болон гадаад улсад МУТСТХуулийн дагуу жагсаалтад орсон болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хориглосон үйл ажиллагааг эрхэлсэн нь тогтоогдсон этгээдтэй санхүүгийн гүйлгээ хийх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

Эрх бүхий байгууллагууд хориг арга хэмжээ хэрэгжүүлэхэд хамтран ажиллах

11. Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагууд. ТС болон ҮОХЗДС-ийн эсрэг тэмцэх НҮБАЗ-ийн тогтоолын хэрэгжүүлэх үйл ажиллагааг Тагнуулын байгууллага хариуцах гүйцэтгэх ба МҮЭ-д тавих шаардлагын хэрэгжилтэнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, СМА нь хууль тогтоомжинд заасан өөрийн эрх мэдлийн хүрээнд хяналт тавьж ажиллана.

Терроризмтэй тэмцэх хуулийн дагуу:

- ❖ **Терроризмтой тэмцэх ажлыг зохицуулах зөвлөл**

Тагнуулын байгууллага нь Терроризмтой тэмцэх ажлыг зохицуулах зөвлөлөөр дамжуулан Терроризмтой тэмцэх тухай хууль болон энэ журамд заасан санхүүгийн хориг арга хэмжээг бодлогын түвшинд хэрэгжүүлэхдээ хяналт шалгалт, хууль сахиулах болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

❖ **Тагнуулын байгууллага**

Терроризмын эсрэг журмын 2.2 дахь заалтад Тагнуулын байгууллага заасан шалгуурт нийцсэн гэж үзэх үндэслэлтэй хүн, хуулийн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр жагсаалтад оруулах, түүний хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох ажиллагааг гүйцэтгэнэ гэж заасан.

- ❖ МҮЭ-тэй холбоотой үйл ажиллагаанд тавих шаардлагыг хэрэгжүүлж, хяналт тавих байгууллагууд бол Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, СМА болон өөрийгөө зохицуулдаг байгууллагууд болно.

МУТСТХуулийн дагуу:

❖ **Үндэсний зөвлөл**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөл ажиллах бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайд батална.

Үндэсний зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүнд прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, СМА-ны төлөөллийг оролцуулна.

Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг Санхүүгийн мэдээллийн алба хэрэгжүүлнэ.

❖ **Хамтын ажиллагааны зөвлөл**

СМА-ны дэргэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны зөвлөл ажиллана.

Хамтын ажиллагааны зөвлөлд гадаад харилцаа, санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, прокурорын байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, СМА-ны төлөөлөл ажиллана.

Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг СМА хэрэгжүүлнэ. Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн, түүний удирдлагыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

12. Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг ФАТФ-ын Зөвлөмж 6, 7-д заасны дагуу хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү гарын авлагад эдгээр зөвлөмжийг бүрэн тусгасан болно.

Гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах

МУТСТХ-ийн 21 дүгээр зүйлд гадаад улсын ижил төстэй байгууллагатай харилцах талаар дараах байдлаар заасан:

21.1.СМА ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг, нууцлалын байдлаар ижил түвшний, гадаад улсын болон олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

21.2.СМА энэ хуулийн 21.1-д заасан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн түүнд шаардлагатай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн өгч болно.

II. ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

Жагсаалтад хувь хүн, хуулийн этгээдийг оруулах

13. Терроризмын эсрэг журмын 2 дугаар бүлэгт НҮБАЗ болон эрх бүхий байгууллага болох Тагнуулын байгууллагаас жагсаалтад хувь хүн, хуулийн этгээдийг оруулах талаар дараах байдлаар заасан:

❖ НҮБАЗ болон түүний хорооноос гаргасан тогтоолын дагуу тодорхойлогдсон хүн, хуулийн этгээдийн жагсаалттай холбоотой хориг арга хэмжээг шууд хэрэгжүүлнэ.

НҮБ-ын цахим хуудас дахь хориг арга хэмжээ авах жагсаалт:
<https://www.un.org/sc/suborg/en/sanctions/un-sc-consolidated-list>

Хориг арга хэмжээтэй холбоотой сүүлийн үеийн мэдээлэл:
<https://www.un.org/press/en>

❖ Тагнуулын байгууллага өөрийн санаачилгаар жагсаалтад оруулж болох буюу аливаа иргэн, хуулийн этгээдийн эсрэг мөрдөн шалгах, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнгээс үл хамааран тэдгээрийг жагсаалтад оруулж болно.

❖ Гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг үндэслэн жагсаалтад оруулж болно.

❖ Тагнуулын байгууллага энэ журмын 2.2-т заасан шалгуурт нийцсэн гэж үзэх үндэслэлтэй хүн, хуулийн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр жагсаалтад оруулах, түүний хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох ажиллагааг гүйцэтгэнэ.

❖ Тагнуулын байгууллага энэ журамд заасны дагуу хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулахдаа эрх бүхий хяналт шалгалтын, хууль сахиулах болон бусад холбогдох байгууллага, ижил төстэй гадаадын байгууллага болон үндэслэл бүхий эх сурвалжийн мэдээ, мэдээллийг ашиглаж болно.

❖ Тагнуулын байгууллага жагсаалтыг холбогдох эрх бүхий байгууллага болон нийтэд шуурхай мэдээлнэ.

Тагнуулын байгууллагын цахим хуудас:
<http://gia.gov.mn/13/item/64>

- ❖ Уг жагсаалтыг нийтэд мэдээлснээс хойш тагнуулын байгууллага ажлын 15 өдрийн дотор жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд дараахь мэдээллийг хүргүүлнэ:
 - Жагсаалт, түүний болзошгүй үр дагавар;
 - Жагсаалттай танилцах, жагсаалтаас хасахтай холбоотой мэдээлэл;
 - Тухайн хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах болсон баримтын нийтэд мэдээлж болох тодорхой хэсэг;
 - Санхүүгийн үйлчилгээ авах болон хөрөнгийг ашиглах зөвшөөрөл авахтай холбоотой НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолын тухай мэдээлэл;
 - Жагсаалтаас хасуулах тухай гомдлыг хүлээн авах НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооны мэдээллийг.

14. **Жагсаалтад оруулахад дараах шалгуур ашиглаж болно.** Террорист үйл ажиллагаанд оролцсон, туслалцаа үзүүлсэн;

- Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхэд туслалцаа үйл ажиллагаа, хөтөлбөр хэрэгжүүлсэн;
- Жагсаалтад орсон этгээдийн өмнөөс, түүний төлөө үйл ажиллагаа явуулсан;
- Жагсаалтад орсон этгээдийн өмчлөлд байгаа, хяналтанд байгаа этгээд;
- Жагсаалтанд орсон этгээдэд хуульд заасан арга хэмжээ, хориг арга хэмжээг авахаас зайлсхийхэд туслалцаа үзүүлсэн этгээд.

15. Тагнуулын байгууллага нь энэ журамд заасан НҮБАЗ-ийн тогтоол болон холбогдох бусад тогтоолд заасан шалгуурт нийцсэн гэсэн үндэслэлээр хувь хүн, хуулийн этгээдийг НҮБАЗ-өөс гаргадаг жагсаалтад шинээр оруулах хангалттай нотлох баримт бүрдсэн гэж үзвэл энэ тухай саналаа гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох хороонд хүргүүлж болно.

Терроризмын эсрэг журмын 3.1-д заасны дагуу жагсаалтад оруулах саналыг дараахь байдлаар боловсруулна:

- жагсаалтад оруулахтай холбоотой НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос баталсан журмыг баримтлах;
- Жагсаалтад шинээр оруулах хүн, хуулийн этгээдийн нэртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл болон тухайн этгээдийг үнэн зөв тодорхойлоход шаардагдах хангалттай бодит мэдээллийг бүрдүүлэх бөгөөд Интерпол, НҮБАЗ-ийн тусгай мэдэгдлийн шаардлагыг хангах;
- Хүн, хуулийн этгээдийг жагсаалтад оруулах үндэслэл, шалтгаан, шалгуурт нийцсэн тухай дэлгэрэнгүй мэдээлэл, нотлох баримт бичиг болон жагсаалтад оруулахаар санал болгож байгаа хүн, хуулийн этгээд нь жагсаалтад байгаа бусад этгээдтэй холбоо хамааралтай эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий хэргийн танилцуулгыг бэлтгэх;
- Монгол Улсыг жагсаалтад санал оруулж буй улс гэдгийг нийтэд мэдэгдэх эсэх асуудлаар тагнуулын байгууллага нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөнө.

16. Терроризмын эсрэг журмын 5 дугаар бүлэгт жагсаалтад орсон этгээдийн хөрөнгөд хориг арга хэмжээг нэн даруй авахаар заасан (үүнийг энэхүү гарын авлагын 8, 9, 10 дугаар заалтад

хамруулсан) бөгөөд хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий этгээд дараах байдлаар тайлагнана:

- ❖ МУТСТХуульд заасан МҮЭ нь энэ журмын дагуу хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, түүнтэй холбогдсон бусад арга хэмжээ авсан бол энэ тухай Тагнуулын байгууллага болон хяналт тавих эрх бүхий байгууллагад мэдээлнэ.
 - ❖ Санхүү, бизнесийн этгээд СМА-нд мэдээлж, тус албаны шаардсан нэмэлт мэдээллийг даруй гаргаж өгнө.
 - ❖ СМА энэ журмын дагуу авсан мэдээллийг Тагнуулын байгууллагад хүргүүлнэ.
17. Терроризмын эсрэг журмын 4.5 дахь заалтад жагсаалтад орсон этгээдийн мөнгөн хуримтлал, хөрөнгөөс тэдгээрийн үндсэн хэрэглээний зардал, тодорхой төрлийн төлбөр, нэн шаардлагатай зардал, үйлчилгээний хураамж буюу гэнэтийн зайлшгүй зардал зэргийг төлж барагдуулах шаардлагатай эсэх асуудлыг Тагнуулын байгууллага хянаж, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолд заасны дагуу шийдвэрлэхээр заасан.

Ш. ЖАГСААЛТТАЙ ТУЛГАХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ТОГТОЛЦОО БИЙ БОЛГОХ

18. МҮЭ нь харилцагч этгээдийг гэрчлэх баримт бичгийг хамгийн сүүлийн байдлаарх жагсаалттай тулгана. Харилцагч, түүний эзэмшиж буй, эсхүүл хянаж буй хуулийн этгээд, түүний хөрөнгийг зарцуулж, гүйлгээ хийж буй этгээдтэй холбоотой мэдээллийг шалгах, харилцагчийг шинжлэх, шалгах арга хэмжээ авна.

МУТСТХуулийн 5.14. дахь заалтад “Дараах нарийвчилсан үйл ажиллагааг тусгасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална.” гэж заасан.

Үүний дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам” (цаашид ТС урьдчилан сэргийлэх журам гэх)-ыг баталсан байна.

19. МҮЭ буюу санхүү, бизнесийн этгээд нь дараах хоёр шатны шинжилгээ хийх шаардлагатай. Үүнд:
- ❖ Эхний шатанд харилцагч болон түүний өмнөөс үйл ажиллагаа эрхэлдэг этгээд нь хориг тогтоосон жагсаалтанд орсон эсэхийг тогтоож, шинжилнэ
 - ❖ Хоёр дахь шатанд жагсаалтанд орсон этгээд болон хориглосон үйл ажиллагатай холбоотой санхүүгийн гүйлгээ, санхүүгийн үйлчилгээг илрүүлж, шинжилнэ.
20. МҮЭ, санхүү, бизнесийн этгээд нь харилцагчийн талаарх мэдээллийг тухай бүр шинэчилж, үнэн зөв, бүрэн бүтэн байлгах шаардлагатай бөгөөд энэхүү мэдээллийг цахим хэлбэрт оруулан хянаж шалгах боломжийг хангах үүрэг хүлээдэг болно.

- ❖ МУТСТ тухай хуулийн 8 дугаар заалтад нийцүүлэн МЭҮ нь баримт материалыг дараах байдлаар хадгална:

| Баримтын төрөл | Хадгалах хугацаа |
|--|--|
| Харилцагчийн данс нээх, бизнесийн харилцаа үүсгэхэд ашигласан бичиг баримт, харилцагчийг таньж мэдэх хүрээнд олж авсан бичиг баримтууд, биеийн байцаалтын хуулбар. | Данс хаагдсанаас эсхүл бизнесийн харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жил. Тохиолдолын чанартай гүйлгээ хийсэн бол гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жил. |
| Харилцагчийн мэдээллийг нарийвчлан шалгах явцад олж авсан баримт, мэдээлэл, Харилцагчийн мэдээлэлд орсон өөрчлөлт, нэмэлт баримт, мэдээлэл, дансны мэдээлэл, Корреспондент харилцааны гэрээ, санамж, бичиг, мөнгө угаах ТС эрсдэлийг тодорхойлоход ашигласан мэдээлэл, харилцагчийг таньж мэдэх, тусгайлан хяналтын дүгнэлт, сэжигтэй гүйлгээтэй холбоотой баримт, материал. | Харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жил. |
| Бэлэн болон бэлэн бус гүйлгээний баримтууд | Гүйлгээ хийгдсэнээс хойш 5-аас доошгүй жил. |

- ❖ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон энэ журмын дагуу хадгалах баримт нь тухайн гүйлгээтэй холбоотой мэдээлийг сэргээж харах боломжтой, холбогдох бүх мэдээллийг агуулсан байх ба хуульд заасан эрх бүхий этгээдийн мэдээлэл авах хүсэлтийн дагуу шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.
- ❖ Баримт материалыг нотлох баримтын түвшинд ашиглах боломжийг хангаж байхаар архивлаж хадгална.

IV. ХАРИЛЦАГЧИЙГ ЖАГСААЛТТАЙ ТУЛГАХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

21. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа

НҮБАЗ болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг албан ёсны мэдээллийн сувгаар зарлах үед болон Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл, СМА эсхүл хяналт шалгалтын чиг үүрэгтэй эрх бүхий байгууллага мэдэгдэл хүргүүлсэн үед МҮЭ жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд, холбоо, бүлэглэл, байгууллагатай шууд болон шууд бусаар холбоотой аливаа харилцагч, гүйлгээ, хөрөнгө байгаа эсэхийг шалгана.

22. Харилцагч нь жагсаалтад орсон этгээд мөн гэдгийг тогтоохын тулд ТС-ээс урьдчилан сэргийлэх журмын даарах заалтын дагуу харилцагчийн талаар мэдээлэл авахаас гадна олон нийтэд нээлттэй эх сурвалжаас зохих мэдээллийг авч, шинжилгээ хийнэ. Үүнд:

- ❖ Журмын бүлэг 2. Эрсдэлийн үнэлгээ
- ❖ Журмын бүлэг 3. Харилцагчийг таньж мэдэх
- ❖ Журмын бүлэг 4. Эцсийн өмчлөгчийг тогтоох
- ❖ Журмын бүлэг 5. Харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагаа
- ❖ Журмын бүлэг 6. Улс төрд нөлөө бүхий этгээд
- ❖ Журмын бүлэг 7. Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа
- ❖ Жухмын бүлэг 8. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх
- ❖ Журмын бүлэг 9. Корреспондент харилцаа

- ❖ Журмын бүлэг 12. Цахим шилжүүлэг
 - ❖ Журмын бүлэг 13. Траст гэрээгээр хөрөнгө захиран зарцуулж байгаа этгээдийн үүрэг
23. МҮЭ нь Тагнуулын байгууллага, СМА-аас жагсаалтыг шинэчлэх бүрт харилцагчтай холбоотой мэдээлэлд тухай бүр шинжилгээ хийх үүрэг хүлээнэ. Харилцагчтай холбоо тогтоохоос өмнө хориг тогтоосон жагсаалтанд ороогүй гэдгийг лавлах үүргийг мэдээлэх үүрэгтэй этгээд хүлээнэ. Үүнд:
- ❖ Харилцагч нь хувь хүн бол дараах мэдээллийг МҮЭ шинжилнэ:
 - Овог нэг, төрсөн огноо, яс үндэс;
 - Регистр, паспортын дугаар;
 - Оршин суудаг хаяг;
 - Эрхэлж буй ажил;
 - Өөр хэн нэг этгээдийг төлөөлөн данс нээлгэж, гүйлгээ хийж байгаа эсэх.
 - ❖ Харилцагч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг МҮЭ шинжилнэ:
 - Байгууллагын нэр;
 - Улсын бүртгэлийн дугаар, регистерийн дугаар;
 - Үйл ажиллагааны чиглэл;
 - Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшлийн бүтэц;
 - Хуулийн этгээдийн удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга;
 - Үйл ажиллагаа явуулдаг хаяг, холбоо барих утасны дугаар;
 - Эцсийн өмчлөгчийн мэдээлэл.
 - ❖ Харилцагч нь хуулийн этгээдийг төлөөлж байгаа бол дараах мэдээллийг МҮЭ шинжилнэ:
 - Эрх зүйн гэрээгээр төлөөлж байгаа бол гэрээний талуудын Улсын бүртгэлийн мэдээлэл;
 - Гэрээнд заасан хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг бусад бүртгэлийн мэдээллүүд;
 - Төлөөлөх эрхтэй этгээдийг томилох, чөлөөлөх эрх бүхий хувь хүн эсхүл хуулийн этгээдийн мэдээллүүд;
 - Хөрөнгийн ашгийг хүртэх эрхтэй этгээдийн мэдээлэл;
 - Траст гэрээний “Settlor” буюу хөрөнгөө траст гэрээний дагуу бусдад шилжүүлж байгаа этгээд, траст гэрээгээр хөрөнгийг захиран зарцуулж байгаа этгээд эсхүл хэд хэдэн этгээд /Trustee(s)/;
 - Траст гэрээний ашиг шимийг хүртэгч /beneficiary(s)/, хэрвээ байгаа бол гэрээний ашиг шимийг хүртэгчийг хамгаалах “protector”, эцсийн өмчлөгчийн мэдээллийг гаргуулан авна.
 - ❖ МҮЭ-ийн харилцагчийн мэдээлэл, жагсаалтад байгаа мэдээллийн хоорон дахь ялгааг арилгах зорилгоор авиазүйн хайлт хийх шаардлагатай.
 - ❖ МҮЭ нь жагсаалт дахь этгээдийн талаар мэдээлийг тогтмол Тагнуулын байгууллага, Санхүүгийн мэдээллийн албанаас гаргадаг мэдээлэлтэй тулгана.

- ❖ Шинээр харилцагчтай харилцаа үүсгэх бол холбогдох мэдээллийг жагсаалттай тулгаж, шинжлэх шаардлагатай.
 - ❖ Харилцагч гүйлгээ хийх бүрт мэдээлэх үүрэгтэй этгээд нь гүйлгээ дамжуулагч, хүлээн авагчийг жагсаалттай тулгаж, шинжлэх шаардлагатай.
 - ❖ Мэдээлэх үүрэгтэй этгээд нь дансны эзэмшигчийг тогтооход дээр заасантай ижил ажиллагааг хэрэгжүүлж, данс, хөрөнгө, бусад актив эзэмшигчид нь хориг тогтоосон жагсаалтанд батгсан этгээд биш гэдгийг тулгана.
24. Данс, хөрөнгө, бусад активын эзэмшигчдийг тодорхойлох шинжилгээг хийхийн тулд МҮЭ нь зохих аргачлалыг хөгжүүлсэн байх шаардлагатай. МҮЭ нь энэхүү гарын авлагын 37, 38 дугаар зүйлд дурьдсан ТС болон ҮОХЗДС-ийн эсрэг хэрэгжүүлэх талаар ФАТФ-аас гаргасан гарын авлагыг мөрдөж ажиллах шаардлагатай болно.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь НҮБАЗ болон эрх бүхий байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлсэн тогтолцоотой байна. Үүнд:

- ❖ Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд, холбоо, бүлэглэл, байгууллагатай холбоотой хөрөнгө мэдээлэх үүрэгтэй этгээдэд байгаа эсэхийг өөрийн мэдээллийн сангаас хайх журамтай байх;
 - ❖ СМА болон хяналт шалгалтын чиг үүрэгтэй эрх бүхий байгууллагаас ирүүлсэн заавар, чиглэлийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдэд байгаа хөрөнгийг нэн даруй хөдөлгөөнгүй болгох, найдвартай хамгаалах үйл ажиллагаатай холбоотой журамтай байх;
 - ❖ Хориг арга хэмжээнд орсон этгээдийн хөрөнгө, мөнгөнд харилцагч болон бусад этгээдийн зүгээс хандах оролдлогыг хянах журам;
 - ❖ Эрх бүхий байгууллага, СМА болон хяналт шалгалтын чиг үүрэгтэй эрх бүхий байгууллагаас ирүүлсэн заавар, чиглэлийн дагуу хөрөнгөд хандах журам;
 - ❖ Эрх бүхий байгууллага, СМА болон хяналт шалгалтын чиг үүрэгтэй эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хариу заавар, чиглэлийн дагуу хөрөнгийг хөдөлгөөнгүй болгосныг цуцлах журам.
 - ❖ Мэдээлэх үүрэгтэй этгээд нь царцаасан хөрөнгө, данс, бусад активт хандах оролдлогуудын талаар мэдээлэх журмыг боловсруулж мөрдөх шаардлагатай.
25. Данс ашиглахгүй харилцагч /“явуулын харилцагч” болон гуравдагч талын харилцагч (чекээр бэлэн мөнгө авах, төлбөрийн даалгавраар гүйлгээ хийх, валют солих г.м.)-ийн гүйлгээ хийхээс өмнө харилцагчийн мэдээллийг хориг тогтоосон жагсаалттай тулгана.

V. ХӨРӨНГӨ, ДАНС, БУСАД АКТИВЫГ ЦАРЦААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.

- ❖ *Терроризмтэй тэмцэх тухай хуульд дараах арга хэмжээ авахаар заасан:*

7.1.7. НҮБАЗ, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад орсон террорист үйлдэл,

террорист хүн, террорист байгууллага, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээд болон тэдгээртэй хамаарал бүхий хувь хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогыг нэн даруй зогсоож холбогдох эрх бүхий байгууллагад 48 цагийн дотор мэдэгдэх.

8.2. Энэ хуулийн 7.1.7-д заасан жагсаалтад орсон этгээд, эсхүл түүний удирдлагад хамаарах этгээд, түүнчлэн НҮБАЗ-өөс зөвшөөрөгдөөгүй этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

9.1. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах байгууллагын болон цэргийн хамтарсан хүч хэрэгслээр тусгайлан хэрэгжүүлэх дараахь ажиллагаа хамаарна:

9.1.6. террор ажиллагаа, террорист үйлдэлд ашиглаж байгаа буюу ашиглахад зориулсан эд хөрөнгө, мөнгө, террорист ажиллагаа, террорист үйлдлээс олсон орлогыг илрүүлэх, хураах.

❖ ***МУТСТХуульд дараах арга хэмжээ авахаар заасан:***

10 дугаар зүйл. Дансанд хяналт тавих

10.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглаж байгаа гэж үзэх үндэслэл байгаа бол Санхүүгийн мэдээллийн алба энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн харилцагчийн дансанд хяналт тавьж болно.

11 дүгээр зүйл. Хөрөнгө битүүмжлэх, түдгэлзүүлэх

11.1. Хийгдэхээр хүлээгдэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй бол Санхүүгийн мэдээллийн албаны дарга тухайн гүйлгээг ажлын гурав хүртэл өдрийн хугацаагаар түдгэлзүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд шүүх уг хугацааг сунгаж болно.

11.2. Энэ хуулийн 11.1-д заасан шийдвэрийг энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бичгээр, боломжгүй бол утсаар мэдэгдэж, шийдвэрийг 24 цагийн дотор хүргүүлнэ.

11.3. Энэ хуулийн 11.1-д заасны дагуу гүйлгээг түдгэлзүүлэх хугацаанд Санхүүгийн мэдээллийн алба дараах арга хэмжээ авна:

11.3.1. Тухайн гүйлгээний талаар гадаад, дотоодын холбогдох байгууллагаас шаардлагатай мэдээлэл цуглуулах;

11.3.2. Тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан гэж үзэх баримт, үндэслэл тогтоогдсон бол энэ тухай эрх бүхий хууль сахиулах байгууллагад мэдэгдэж холбогдох баримт бичгийг нэн даруй шилжүүлэн шалгуулах;

11.3.3. Тухайн гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсан гэдэг нь тогтоогдвол гүйлгээг түдгэлзүүлэх тухай шийдвэрийг цуцалж, энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд нэн даруй мэдэгдэх.

❖ ***Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд дараах арга хэмжээ авахаар заасан:***

21.1 дүгээр зүйл. Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах

1. Шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

2. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргах, давж заалдах хугацаа дуустал хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тусгай байранд хадгалж, энэ тухай баримтыг хавтаст хэрэгт хавсаргана.
3. Хураан авсан үндэсний болон гадаад валютыг тусгай дансанд байршуулна.
4. Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах талаар гаргасан оролцогчийн хүсэлтийг үндэслэн тэдгээрийг хаана хадгалахыг шүүх, прокурорын шийдвэрт тусгайлан зааж болно.
5. Гэмт хэргийн ул мөр агуулсан эд мөрийн баримтаар хураагдсан үндэсний болон гадаад валют нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт хамаарахгүй.
6. Тусгай хадгалалт, хамгаалалт шаардлагатай хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, шинжилгээний объектыг шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, шинжилгээний байгууллагын шинжээчийн саналаар тухайн байгууллагаас өөр байгууллагад хадгалуулж болно.
7. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, шинжилгээний объектыг хадгалах, хамгаалах, хяналт тавих үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтан тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

21.2 дугаар зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх

1. Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ.
2. Шүүх, прокурорын шийдвэрээр хураан авсан эд мөрийн баримт овор хэмжээ ихтэй, эсхүл бусад шалтгаанаар хадгалах боломжгүй бол мөрдөгч байгаа газарт нь битүүмжилнэ.
3. Эд хөрөнгийг битүүмжлэхдээ эд хөрөнгөө бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, өөрт нь, эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэнэ.
4. Мөрдөгч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хадгалах, хамгаалах үүрэг хүлээсэн хүнд эд хөрөнгийг хүлээлгэн өгч, хуульд заасан хариуцлагыг сануулж, гарын үсэг зуруулна.
5. Эд хөрөнгө битүүмжлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хүний өдөр тутмын зайлшгүй хэрэгцээний эд зүйлийг битүүмжилж болохгүй.
6. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хураан авах, нэгжлэг хийх ажиллагаатай хамт явуулж болно.

21.3 дугаар зүйл. Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах хугацаа

1. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг давж заалдах хугацаа дуустал эд мөрийн баримтыг хадгална.
2. Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын эзэмшлийн талаар гарсан маргааныг иргэний журмаар шийдвэрлэхээр бол тэдгээрийг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болтол хадгална.

21.4 дүгээр зүйл. Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүргүүлэх

1. Хэргийг өөр мөрдөгчид болон шүүхэд шилжүүлэхдээ хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хамт хүргүүлнэ.

2. Хэргийг шилжүүлэхэд овор хэмжээний хувьд болон бусад шалтгаанаар хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хамт хүргүүлэх боломжгүй бол түүнийг шүүхийн шийдвэр гаргал журмын дагуу хадгалж, энэ тухай баримтыг хавтаст хэрэгт хавсаргана.
3. Шинжилгээний объектыг хүргэх, тээвэрлэх боломжгүй тохиолдолд шинжээчийг шинжилгээний объект байгаа газар чөлөөтэй нэвтрүүлэх, шинжилгээ хийх нөхцөлөөр хангах үүргийг шинжээч томилсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээнэ.

21.5 дугаар зүйл. Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шийдвэрлэх

1. Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх бодит үндэслэл бий болсон, эсхүл түргэн муудах, гэмтэх, устгах, эсхүл хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл чанар нь муудах хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг эзэмшигчид нь буцааж өгөх боломжгүй тухай прокурорын саналыг үндэслэлтэй гэж үзвэл шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргаж болно:

- 1.1. хэрэгцээний дагуу зохих байгууллагад шилжүүлэх;
- 1.2. хадгалуулахаар зохих байгууллагад шилжүүлэх;
- 1.3. худалдан борлуулж орлогыг тусгай дансанд хадгалах;
- 1.4. устгуулахаар зохих байгууллагад шилжүүлэх.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тухайн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шилжүүлсэн, хадгалсан, худалдан борлуулсан, устгасан тохиолдолд шүүхийн шийдвэрээр эзэмшигчид нь адил төрөл, чанарын эд зүйлийг олгох, эсхүл үнийг төлнө.
3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаанд прокурор, мэргэжилтнийг оролцуулж, тэмдэглэл үйлдэн устгасан, шилжүүлсэн, худалдан борлуулсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын жагсаалтыг хэрэгт хавсаргана.
4. Шинжилгээнд ирүүлсэн шинж чанараа алдаж шинжилгээнд дахин ашиглах боломжгүй болсон, эсхүл дээжийг нь санд авч архивласан биологийн гаралтай эд мөрийн баримт болох цус, үрийн шингэн, шүлс, шээс, ходоодны агууламж, үс, хумс, яс, эд, эс зэрэг бусад зүйлийг шинжилгээ хийж дууссаны дараа шүүхийн шинжилгээний байгууллага прокурорын зөвшөөрлөөр устгана.
5. Шинжээч шинжилгээний объектыг энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу устгасан, устгуулахаар шилжүүлсэн талаар прокурорт мэдээлэл хүргүүлнэ.
6. Хавтаст хэргийн материал, хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх болон энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4-т заасан ажиллагааны журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор хамтран батална.

Шалгах явцад харилцагчийн мэдээлэл жагсаалтад орсон этгээдийн мэдээлэлтэй нийцэж байвал авах арга хэмжээ

26. Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 7.1.7 болон 8.2 дахь заалтын дагуу хэрэв хориг тогтоосон жагсаалтад заагдсан этгээдийн мэдээлэл харилцагчийн мэдээлэлтэй нийцэж байвал МҮЭ нь зохих шимтгэлийг авч, хөрөнгийг царцааж СМА болон бусад эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ:
- ❖ НҮБАЗ, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Монгол гаргасан жагсаалтад орсон террорист үйлдэл, террорист хүн, террорист байгууллага, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээд болон тэдгээртэй хамаарал бүхий хувь хүн, хуулийн

этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогыг нэн даруй зогсоож холбогдох эрх бүхий байгууллагад 48 цагийн дотор мэдэгдэнэ.

- ❖ Энэ хуулийн 7.1.7-д заасан жагсаалтад орсон этгээд, эсхүл түүний удирдлагад хамаарах этгээд, түүнчлэн НҮБАЗ-өөс зөвшөөрөгдөөгүй этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

27. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын 14.3-ын дагуу хэрэгжүүлнэ.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд, холбоо, бүлэглэл, байгууллага болон тэдгээрийн нэрийн өмнөөс шууд болон шууд бусаар эсхүл тэдгээрийн зааврын дагуу үйл ажиллагааг явуулж байгаа этгээдийн хөрөнгө, орлого байгаа гэж үзвэл МУТСХуулийн 6^{1.2} -т заасны дагуу нэн даруй дараах арга хэмжээг авах үүрэгтэй:

- ❖ Холбогдох хууль болон журмын дагуу мөнгө, хөрөнгийн хөдөлгөөнийг нэн даруй зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх, захиран зарцуулах боломжгүй болгоно.

28. Нэмэлт мэдээлэл авах тухай

Хэрэв мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг жагсаалтад орсон этгээд мөн эсэхийг тогтоож чадахгүй бол мэдээлэх үүрэгтэй этгээд нь зохих мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдэгдэж, зохих мэдээлэл авах шаардлагатай.

Нэмэлт мэдээлэл авахдаа харилцагчид сэжиг авахуулахгүй байх хэлбэрээр зохих мэдээллийг олж авах шаардлагатай. Нэмэлт мэдээлэл авахад харилцагчийн хөрөнгө, данс, бусад актив хөрөнгө гаргахаас сэргийлэх шаардлагатай.

29. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь СМА болон холбогдох эрх бүхий байгууллагад дараах мэдээллийг хүргүүлнэ:

- Хөдөлгөөнгүй болгосон хөрөнгийн талаарх мэдээлэл;
- Хөрөнгийн өмчлөгч болон захиран зарцуулагчтай холбоотой мэдээлэл;
- Хөдөлгөөнгүй болгосон хөрөнгөтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

30. МҮЭ нь царцаагдсан хөрөнгө, дансыг ашиглах, гүйлгээ хийх оролдлого гаргахыг хянах, гарахад зохих арга хэмжээ авах тогтолцоо, зохицуулалт бий болгох шаардлагатай. Ийм үйлдэл гарсан тохиолдолд МҮЭ нь нэн даруй Тагнуулын байгууллага, Санхүүгийн мэдээллийн алдбанд мэдэгдэх шаардлагатай болно.

31. **Жагсаалтаас гаргах, хөрөнгө чөлөөлөх**

Терроризмын эсрэг журмын 2.1-д заасны дагуу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний холбогдох хорооноос гаргасан жагсаалттай холбогдуулж, уг жагсаалтаас хасах болон хөрөнгө чөлөөлөхтэй холбоотой дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- ❖ Жагсаалтад оруулсныг эс зөвшөөрч байгаа хүн, хуулийн этгээдийн гомдлыг Тагнуулын байгууллага хянаж шийдвэрлэнэ;
 - ❖ Тагнуулын байгууллага гомдлыг хянаж шийдвэрлэхдээ шаардлагатай мэдээлэл авах, тодорхой асуултад хариулт авах зорилгоор гомдол гаргагчаас нэмэлт тайлбар авч болно;
 - ❖ Тагнуулын байгууллага гомдлыг хянахын зэрэгцээ, өөрийн санаачилгаар жагсаалтад оруулсан хүн, хуулийн этгээдийн мэдээллийг жагсаалтад оруулах шалгуурт нийцэх эсэхийг 5 жил тутамд хянан баталгаажуулна;
 - ❖ Тагнуулын байгууллага жагсаалтад оруулах шалгуурт нийцээгүй, эсхүл цаашид нийцэхгүй гэж үзвэл уг хүн, хуулийн этгээдийг даруй жагсаалтаас хасах.
32. Тагнуулын байгууллага жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийг жагсаалтад орох шалгуурт нийцээгүй, эсхүл цаашид нийцэхгүй гэх үндэслэлтэй бол НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл эсхүл түүний хороодод жагсаалтаас хасах тухай хүсэлт тавьж болно.
- ❖ Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд нь НҮБАЗ, түүний холбогдох хороонд хандан жагсаалтаас хасах тухай гомдол гаргаж болно.
 - ❖ Хүн, хуулийн этгээд Терроризмтой тэмцэх тухай хуулийн 7.1.7-д, эсхүл Терроризмын эсрэг журмын 2.1, 2.2-т заасны дагуу хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээнд үндэслэлгүйгээр өртсөн гэж үзвэл тагнуулын байгууллагад хөрөнгийг чөлөөлөх тухай гомдол гаргана. Гомдлыг ажлын 30 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

Царцаагдсан хөрөнгө, данс чөлөөлөх шийдвэр гарсан бол

Тагнуулын байгууллага энэ журмын 4.3-т заасны дагуу хүлээн авсан гомдлыг хянаж, гомдол гаргагч нь жагсаалтад ороогүйг нягтлан шалгасны үндсэн дээр хөрөнгийг чөлөөлөх шийдвэр гаргаж болно.

- ❖ Тагнуулын байгууллага НҮБАЗ-ийн болон энэ журамд заасан жагсаалтаас хассан, эсхүл хөрөнгийг чөлөөлсөн тухай шийдвэр гарсан даруй холбогдох хүн, хуулийн этгээд, санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч бусад этгээдэд бичгээр мэдэгдэнэ.
- ❖ Тагнуулын байгууллага нь жагсаалтаас хассан, хөрөнгийг чөлөөлсөн тухай энэ журмын 4.7-д заасан шийдвэрийг даруй хэрэгжүүлж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

Гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах

Тагнуулын байгууллага энэ журамд заасан үүргээ хэрэгжүүлэх явцад хууль ёсны гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- ❖ Жагсаалтад оруулсны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдийн хөрөнгө чөлөөлүүлэхийг хүссэн гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэнэ;

- ❖ Гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор шийдвэрлэж, холбогдох талуудад мэдэгдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 30 хүртэл өдрөөр сунгана;
 - ❖ Тагнуулын байгууллага энэ журмын 4.9-д заасан гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор нэмэлт мэдээлэл авах, тодорхой асуултад хариулт авахын тулд гомдол гаргагч болон холбогдох бусад этгээдийг дуудан ирүүлэх эрхтэй.
 - ❖ Энэ журмын дагуу тагнуулын байгууллагын гаргасан аливаа шийдвэрийг хууль ёсны эрх ашиг, сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн этгээд зохих эрх бүхий байгууллагаар хянуулах эрхтэй.
33. Жагсаалтад орсон этгээд санхүүгийн гүйлгээ, санхүүгийн үйлчилгээг авахыг МҮЭ-ээс тогтоосон бол гүйлгээ хийх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно. Энэ талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэж, Санхүүгийн мэдээллийн албанд сэжигтэй гүйлгээний мэдээлэл ирүүлэх үүрэг хүлээнэ.

VI. БУСАД

34. Хэрэв МҮЭ нь харилцагчийг жагсаалтад орсон эсэхийг тогтооход эргэлзээтэй байгаа бол МҮЭ харилцагчид сэжиг төрүүлэхгүйгээр нэмэлт мэдээлэл авна. Үүнд хөрөнгө гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсны дараа ийм нэмэлт мэдээллийг авах шаардлагатай.
35. МҮЭ нь ТС болон ҮОХЗДС эсрэг тэмцэх талаар авах арга хэмжээг хэрэгжүүлэх талаар өөрсдийн ажилчдын сургалтыг зохион байгуулна.

VII. ХАРИУЦЛАГА

36. Хууль тогтоомжийг зөрчсөн этгээд холбогдох хуулинд заасан хариуцлагаа хүлээлгэнэ.

Эрүүгийн тухай хуульд дараах байдлаар заасан:

18.6 дугаар зүйл. Мөнгө угаах

1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг:
 - 2.1. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;
 - 2.2. байнга тогтвортой үйлдэж;
 - 2.3. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
4. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

29.10 дугаар зүйл. Террор үйлдэхийг санхүүжүүлэх

1. Террорист хүн, террорист байгууллага, террор ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд, шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

29.11 дүгээр зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх

1. Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Терроризмтэй тэмцэх тухай хуульд дараах байдлаар заасан:

15 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 15.1. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МУТСТХуулийн 12 дугаар зүйлд зааны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд дараах тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө:

- ❖ СМА болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны, мэргэжлийн, мэргэжлийн үйл ажиллагааны, үйлчлүүлэгчийн, аж ахуйн нэгж, байгууллагын, бизнесийн болон бусад нууц задруулсан гэж үзэхгүй.

- ❖ Энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсныг тогтоосон нь тухайн мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.
- ❖ Тодорхой гүйлгээг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь энэ хуулийн 4.1-д заасан этгээд, түүний удирдлага, ажилтан болон СМА, тус албаны албан хаагчийг Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад хуульд заасан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.

Зөрчлийн тухай хуульд дараах байдлаар заасан:

5.10 дугаар зүйл. Терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих

1. Терроризмоос сэргийлэхтэй холбогдсон аливаа мэдээллийг төрийн холбогдох байгууллагад даруй өгөх, эсхүл террор ажиллагаа, үйлдэлд өдөөн хатгасан аливаа явуулгад автахгүй байх, эсхүл терроризмоос сэргийлэх арга хэмжээ, террор үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Зохицуулах зөвлөлийн терроризмоос сэрэмжлүүлэх талаар өгсөн үүрэг, эсхүл террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг удирдах шуурхай штабын хүсэлт, шаардлагыг хуулийн этгээд даруй биелүүлэх, эсхүл түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс сэргийлэхтэй холбогдсон аливаа мэдээллийг төрийн холбогдох байгууллагад даруй өгөх, эсхүл террор ажиллагаа, үйлдэлд өдөөн хатгасан аливаа явуулгад автахгүй байх, эсхүл үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс сэргийлэх арга хэмжээ, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Зохицуулах зөвлөлийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс сэрэмжлүүлэх талаар өгсөн үүрэг, эсхүл үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг удирдах шуурхай штабын хүсэлт, шаардлагыг хуулийн этгээд даруй биелүүлэх, эсхүл түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

VIII. НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

37. ФАТФ-аас гаргасан Зөвлөмж, гарын авлага

Монгол Улсын эрх бүхий байгууллагаа, МҮЭ нь ТС болон ҮОХЗДС эсрэг тэмцэхэд чигэлэсэн үйл ажиллагаандаа ФАТФ-аас гаргасан Зөвлөмж, гарын авлагыг мөрдөж, ашиглана.

- ❖ ФАТФ-аас гаргасан Зөвлөмж 7 нь ҮОХЗДС-ийн эсрэг үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар гаргасан зөвлөмжүүдийг багтаасан байна.

ФАТФ-ын Зөвлөмж 7 хэрхэн хэрэгжүүлэх талаар “ҮОХЗДС-ийн эсрэг үйл ажиллагааны гарын авлага”-ыг 2018 онд гаргасан.

www.FATF-gafi.org/publications/FATFrecommendations/documents/guidance-counter-proliferation-financing.html

38. ФАТФ-аас гаргасан Зөвлөмж 6 нь ТС-ийн эсрэг үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар гаргасан зөвлөмжүүдийг багтаасан байна.

ФАТФ-ын Зөвлөмж 6 хэрхэн хэрэгжүүлэх талаар “ТС-ийн эсрэг үйл ажиллагааны гарын авлага”-ыг 2013 онд гаргасан.

<http://www.FATF-gafi.org/media/FATF/documents/recommendations/BPP-Fin-Sanctions-TF-R6.pdf>

39. НҮБАЗ-ийн тогтоолууд

- ❖ **Ал-кайда болон Исламын улсын эсрэг НҮБАЗ-ийн тогтоолууд:**

- 1999 оны 10 дугаар сарын 15-нд баталсан 1267 дугаар тогтоол;
- 2011 оны 6 дугаар сарын 17-нд баталсан 1989 дугаар тогтоол;
- 2015 оны 12 дугаар сарын 17-нд баталсан 2253 дугаар тогтоол;
- Дээрх тогтоолуудыг дагалдаж гарсан НҮБАЗ-ын тогтоолууд.

- ❖ **Талибан хөдөлгөөний эсрэг НҮБАЗ-ын тогтоолууд:**

- 2011 оны 6 дугаар сарын 17-нд баталсан 1988 дугаар тогтоол
- Дээрх тогтоолыг дагалдаж гарсан НҮБАЗ-ын тогтоолууд

- ❖ **Терроризмын эсрэг НҮБАЗ-ын тогтоолууд:**

- 2001 оны 9 дүгээр сарын 28-нд баталсан 1373 дугаар тогтоол;
- Дээрх тогтоолыг дагалдаж гарсан НҮБАЗ-ын тогтоолууд

- ❖ **БНАСУ-тай холбоотой НҮБАЗ-ийн тогтоолууд:**

- 2006 оны 10 дугаар сарын 14-нд баталсан 1718 дугаар тогтоол;
- 2009 оны 6 дугаар сарын 12-нд баталсан 1874 дугаар тогтоол;
- 2013 оны 1 дүгээр сарын 22-нд баталсан 2087 дугаар тогтоол;
- 2016 оны 3 дугаар сарын 2-нд баталсан 2270 дугаар тогтоол;
- 2016 оны 11 дугаар сарын 30-нд баталсан 2321 дугаар тогтоол;
- 2017 оны 8 дугаар сарын 5-нд баталсан 2371 дугаар тогтоол;
- 2017 оны 9 дүгээр сарын 11-нд баталсан 2375 дугаар тогтоол;
- 2017 оны 12 дугаар сарын 22-нд баталсан 2397 дугаар тогтоол;

- Дээрх тогтоолуудыг дагалдаж гарсан НҮБАЗ-ын тогтоолууд.

❖ **Иран улстай холбоотой НҮБАЗ-ийн тогтоолууд:**

- 2006 оны 12 дугаар сарын 27-нд баталсан 1737 дугаар тогтоол;
- 2015 оны 7 дугаар сарын 20-нд баталсан 2231 дугаар тогтоол;
- Дээрх тогтоолуудыг дагалдаж гарсан НҮБАЗ-ын тогтоолууд.

40. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол доор дурьдсан нэр томъёонуудыг 41 дэх заалтад зааснаар хэлнэ.

41. **Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт дараах нэр томъёоллыг дор дурдсан утгаар хэлнэ гэжээ:**

3.1.1. “Терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааг;

3.1.2. “Олон улсын терроризм” гэж олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх зорилго бүхий улс дамжсан терроризмыг;

3.1.10. “Терроризмтой тэмцэх” гэж терроризмоос сэргийлэх ажиллагаа, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны нэгдлийг;

3.1.12. “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах аливаа үйл ажиллагааг.

МУТСТХууль дараах нэр томъёоллыг дор дурдсан утгаар ойлгоно гэжээ. Үүнд:

3.1.1. “Мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;

3.1.2. “Терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист байгууллага, террорист хүн, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг;

3.1.6. “Эцсийн өмчлөгч” гэж:

- 3.1.6.a. харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- 3.1.6.б. харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- 3.1.6.в. хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- 3.1.9. “Хөрөнгө” гэж Иргэний хуулийн 483 дугаар зүйлд заасныг .
- 3.1.10. “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 2-т заасныг”
- 3.1.13. “Хөрөнгийг удирдах” гэж харилцагчийн хөрөнгийг түүний нэрийн өмнөөс ашиглах, эзэмших, захиран зарцуулах үйл ажиллагаа.

Бусад нэр томьёо

“Актив”-бүх төрлийн хөрөнгө, сан, санхүүгийн эх үүсвэр, түүн дотор хөдлөх болон үл хөдлөх, биет болон биет бус, материалаг болон материалаг бус, бодит болон ирээдүйд ашиг өгөх:

- Бэлэн мөнгө;
- Цахим валют, криптовалюта;
- Банкны зээл, банкны чек, аяллын чек, мөнгөн гүйлгээ;
- Үнэт метал, үнэт чулуу;
- Үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, усан онгоц;
- Хувьцаа, үнэт цаас, бонд, төсөл;
- Батлан даалт, гүйцэтгэлийн бонд, өр төлөх эрх шилжүүлэх болон бусад санхүүгийн үүрэг;
- Аккредитив, тээвэрлэлтийн баримт, худалдах гэрээ;
- Экспортын санхүүжилтийн хэрэгслүүд;
- Байгалын баялаг;
- Хөдөлмөрийн эх үүсвэр, үйлчилгээ;
- Хөрөнгө, бараа, үйлчилгээ авахад ашиглагдах бусад эдийн засгийн эх үүсвэр;
- Актив эзэмших эрх, ашгийг гэрчлэх хуулийн баримт бичгүүд;
- Активаас хүртэх хүү, шимтгэл, орлого болон бусад ашиг.

❖ “Эрх олгох” гэдэг нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Тагнуулын байгууллагаас үйлдэл хийх, эс үйлдэх эрхийг Терроризмтэй тэмцэх тухай хуулийнд дагуу олгохыг хэлнэ.

❖ “Үндсэн зардал” гэж дараах зүйлийн зардлыг хэлнэ:

- Хүнс худалдаж авах;
 - Түрээс, зээл төлөх;
 - Эмнэлгийн үйлчилгээ авах, эм худалдаж авах;
 - Татвар төлөх;
 - Даатгалын шимтгэл төлөх;
 - Үйл ажиллагааны шимтгэл төлөх;
 - Ажлын хөлс төлөх;
 - Хуулийн үйлчилгээний хөлс төлөх;
 - Царцаагдсан актив хөрөнгийн засвар үйлчилгээний шимтгэл төлөх;
 - НҮБАЗ-ийн тогтоолыг зөрчөөгүй бусад төрлийн зардал.
- ❖ “Гэрээний дагуу хүлээх үүрэг” гэж НҮБАЗ-ийн тогтоолыг зөрчихгүйгээр холбогдох этгээдийн НҮБАЗ-ийн жагсаалтад орохоос өмнө нь байгуулсан гэрээний дагуу хүлээх үүргийг хэлнэ.
- ❖ “Хяналт” гэж санхүү, үйл ажиллагааны бодлого хэрэгжүүлэхэд нөлөөлөх, эрх мэдэл хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Үүнд хуулийн болон адил тэгш хүчинтэй эсэх, болон хууль ёсны болон адил тэгш эрхтэй эсэхээс үл хамааран траст, гэрээ, тохиролцоо, үйл ажиллагааны үр дүнд хяналт хэрэгжүүлэхийг ойлгоно. Хяналтанд байх гэдэг нь ижил утгатай.
- ❖ “Санхүүгийн бус бизнес болон мэргэжил” гэдэг нь:
- Казиногийн үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, хуулийн этгээд;
 - Үл хөдлөх хөрөнгө, үнэт метал, үнэт чулууны зуучлагч;
 - Төлөөлөгч, захирал, нарийн бичиг, төлөөллийн хувьцаа эзэмшигч, траст буюу компанийн үйлчилгээ үзүүлэгч, байнгийн буюу шуудангийн хаяг бүртгүүлэгч;
 - Үл хөдлөх хөрөнгө худалдах, харилцагчийн бэлэн мөнгө, үнэт цаас, бусад хөрөнгөтэй холбоотой гүйлгээ хийхэд, банкны болон үнэт цаасны дансыг удирдахад туслалцаа үзүүлж, гүйцэтгэдэг нягтлан бодогч, хуульч, нотариатч зэрэг мэргэжлийн байгууллага, хувь хүн;
 - Хандив цуглуулах ажлыг зохион байгуулагч.
- ❖ “Хуулийн этгээд” гэж хувь нийлүүлсэн этгээд, бүлэг, холбоо, байгууллагыг хэлнэ.
- ❖ “Ер бусын зардал” гэж үндсэн бус, гэрээний дагуух зардлыг хэлнэ:
- Шаардлага гарсан;
 - НҮБАЗ-ийн тогтоолыг зөвшөөрөөгүй;
 - НҮБАЗ болон Хороогоор батлуулсан.
- ❖ “Санхүүгийн байгууллага” гэж харилцагчийн төлөө болон өмнөөс нь дараах үйл ажиллагаа явуулдаг этгээд:
- Харилцах, хадгаламж татах;
 - Зээл олгох, факторинг, форфейт, санхүүгийн гүйлгээ хийх;
 - Санхүүгийн лизинг;
 - Валютын гүйлгээ хийх;

- Төлбөрийн хэрэгсэл болох кредит болон дебит карт гаргах, чек, аяллын чек бичих; мөнгөн гүйлгээ хийх;
 - Санхүүгийн баталгаа гаргах;
 - Мөнгөний зах зээлийн хэрэгслүүдийн арилжаа;
 - Валютын арилжаа хийх;
 - Валют, хүү, индексд суурилсан хэргслүүдийн арилжаа хийх;
 - Шилжих үнэт цаасны арилжаа;
 - Барааны фьючерс;
 - Үнэт цаас гарах, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх;
 - Бэлэн валют хадгалах, үнэт цаас удирдах;
 - Бусад этгээдийн өмнөөс активт хөрөнгө оруулалт хийх, удирдах;
 - Даатгалын үйлчилгээ үзүүлэх;
 - Валют солих.
- ❖ “Санхүүгийн хориг” гэж НҮБАЗ-ийн тогтоол, Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 7.1.7, 8.2 дахь заалтад заасан зүйл.
 - ❖ “Царцаах” гэж актив хөрөнгийг худалдах, нийлүүлэх, зээлэх, шилжүүлэх, хөрвүүлэх, ашиглах, хөдөлгөхөөс сэргийлэх үйл ажиллагааг хэлнэ.
 - ❖ “Эзэмших” гэж шууд болон шууд бусаар 25-аас дээш хувийг эзэмших эрхийг хэлнэ.
 - ❖ “Этгээд” гэж хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
 - ❖ “Хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага” гэж Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 17 дахь заалтын дагуу хяналт шалгалт хийх эрхийг авсан төрийн байгууллагыг хэлнэ.